

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/274/ НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ҮОМШӨ	Үйлдвэрлэл осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/180
танай _____-ны № _____-г

ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ХУНТОГОС ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 24,451.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул дараах асуудлуудыг хязгаарлалттай дүгнэлтийн үндэс гэж үзлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд 20,495.9 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн
- Цахим төлбөрийн и баримтын бүрдэл хангаагүй 1,317.6 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн
- ХХОАТ-ыг 2,637.6 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 6 сарын 21-ны өдрийн 241 тоот тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох” албан хаагчдын цалингийн хэмжээнд өөрчлөлт орсон байна.

019020241

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Тайлант 32,358.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	261,257,482.20	206,054,882.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	202,313,158.13	145,405,732.69
312	Банканд байгаа бэлэн мөнгө	202,313,158.13	145,405,732.69
3121	Төгрөг	202,313,158.13	145,405,732.69
31	Төрийн сангийн харилцах	202,313,158.13	145,405,732.69
33	АВЛАГА	26,662.75	0.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	26,662.75	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58,917,661.32	60,649,150.15
351	Түүхий эд материал	40,871,032.32	34,443,767.25
35110	Тусгай зориулалттай материал	40,871,032.32	34,443,767.25
354	Хангамжийн материал	18,046,629.00	26,205,382.90
35410	Бичиг хэргийн материал	3,444,700.00	3,550,515.00
35420	Аж ахуйн материал	14,415,419.00	14,139,814.00
35450	Барилга засварын материал	135,000.00	135,000.00
35460	Хүнсний материал	51,510.00	1,646,893.00
35470	Бусад хангамжийн материал		6,733,160.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,546,127,475.69	1,502,981,725.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,546,127,475.69	1,502,981,725.42
392	Биет хөрөнгө	1,545,616,475.69	1,502,641,058.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,353,953,143.08	1,353,953,143.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	(133,396,534.29)	(161,709,604.53)
39205	Машин тоног төхөөрөмж	188,427,226.26	234,949,198.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,905,086.71)	(76,684,187.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,172,138.52	156,195,558.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,715,475.20)	(45,144,113.94)
39217	Номын фонд	41,081,064.03	41,081,064.03
393	Биет бус хөрөнгө	511,000.00	340,666.6
39301	Программ хангамж	511,000.00	511,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(170,333.40)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,807,384,957.89	1,709,036,608.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		20,495,881.93
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		20,495,881.93
413	Өглөг		20,495,881.93
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		20,495,881.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,807,384,957.89	1,688,540,726.33
51	Засгийн газрын хувь оролцоо	1,807,384,957.89	1,688,540,726.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	331,655,608.50	331,655,608.50
51101	Өмч:-төрийн	331,655,608.50	331,655,608.50
512	Хуримтлагдсан үр дүн	1,097,744,902.63	978,912,999.07
51210	Өмнөх үеийн үр дүн	1,097,744,902.63	1,097,757,230.63
51220	Тайлант үеийн үр дүн		(118,844,231.56)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	377,984,446.76	377,972,118.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,807,384,957.89	1,709,036,608.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,993,071,813.36	1,297,425,050.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,602,763,345.36	32,358,702.90
120	Нийтлэг татварын бус орлого	1,602,763,345.36	32,358,702.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,602,763,345.36	32,358,702.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,317,600.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,013,075.00	
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,599,432,670.36	32,358,702.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	309,000,768.00	233,062,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,081,307,700.00	1,032,003,948.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,081,307,700.00	1,032,003,948.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,205,300.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	60,205,300.00	0.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	248,737,800.00	233,062,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	248,737,800.00	233,062,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	57,668.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	57,668.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,185,772.355.47	1,405,796,407.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,185,772.355.47	1,405,796,407.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,094,554,151.16	1,344,075,197.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,865,188.72	817,792,204.11
210101	Үндсэн цалин	428,695,040.82	588,004,953.59
210102	Нэмэгдэл	205,304,179.93	204,635,882.59
210104	Урамшуулал	34,865,967.97	25,151,367.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,087,818.96	102,173,909.08
210201	Тэтгэврийн даатгал	58,960,986.13	70,159,555.54
210202	Тэтгэмжийн даатгал	6,741,338.01	8,411,225.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,091,808.12	6,564,051.67
210204	Ажилгүйдлийн даатгал	1,195,134.74	1,548,252.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,098,551.96	15,490,824.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,479,506.98	251,558,281.93
210301	Гэрэл, цахилгаан	36,560,807.98	47,258,041.89
210302	Түлш, халаалт	141,806,577.00	168,835,971.04

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	12,112,122.00	35,464,269.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,783,680.00	1,031,500.00
210401	Бичиг хэрэг	1,168,400.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	39,600.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,575,680.00	1,031,500.00
2105	Норматив зардал	52,767,780.00	30,736,130.00
210502	Хоол, хүнс	52,767,780.00	30,736,130.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,452,800.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	4,452,800.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,148,600.00	7,582,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,317,600.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	6,148,600.00	6,264,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,968,776.50	131,200,972.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,492,212.15	27,223,570.07
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	7,995,510.00	8,205,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,481,054.35	95,771,902.52
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,218,204.31	61,721,210.00
	Бусад урсгал шилжүүлэг	87,768,118.00	61,721,210.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,112,818.00	61,721,210.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,454,800.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,200,500.00	
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	3,450,086.31	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,450,086.31	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,807,299,457.89	(108,371,356.81)
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		10,472,874.75
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		10,472,874.75
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		(10,472,874.75)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,807,299,457.89	(118,844,231.56)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,393,724,643.00	1,265,066,348.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,416,175.00	
120	Нийтлэг татварын бус орлого	3,416,175.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,416,175.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,403,100.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,013,075.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,390,308,468.00	1,265,066,348.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,081,307,700.00	1,032,003,948.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,205,300.00	
131104	Дээд шатны захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	60,205,300.00	
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	248,737,800.00	233,062,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	248,737,800.00	233,062,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	57,668.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	57,668.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,135,623,664.87	1,285,218,873.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,135,623,664.87	1,285,218,873.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,018,085,988.56	1,223,036,523.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,822,114.86	817,765,541.36
210101	Үндсэн цалин	428,651,966.96	588,367,698.90
210102	Нэмэгдэл	205,304,179.93	204,696,474.53
210104	Урамшуулал	34,865,967.97	24,701,367.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,114,481.72	102,173,909.08
210201	Тэтгэврийн даатгал	58,987,648.88	70,159,554.17
210202	Тэтгэмжийн даатгал	6,741,338.01	8,411,225.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,091,808.12	6,564,051.67
210204	Ажилгүйдлийн даатгал	1,195,134.74	1,548,252.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,098,551.97	15,490,825.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,479,506.98	231,062,400.00
210301	Гэрэл, цахилгаан	36,560,807.98	47,258,041.89
210302	Түлш, халаалт	141,806,577.00	168,835,971.04
210303	Цэвэр, бохир ус	12,112,122.00	14,968,387.07
2105	Норматив зардал	26,411,300.00	31,870,873.00
210502	Хоол, хүнс	26,411,300.00	31,870,873.00

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,600,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	4,600,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,494,060.00	8,537,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,317,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,494,060.00	7,219,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,164,525.00	29,626,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,105,015.00	19,517,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,059,510.00	10,109,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,537,676.31	62,182,350.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,087,590.00	62,182,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	56,432,290.00	62,182,350.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,454,800.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,200,500.00	
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт	3,450,086.31	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,450,086.31	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	258,100,978.13	(20,152,525.44)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	55,787,820.00	36,754,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,787,820.00	36,754,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	55,787,820.00	36,754,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	55,787,820.00	36,754,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(55,787,820.00)	(36,754,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	202,313,158.13	(56,907,425.44)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	202,313,158.13
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	202,313,158.13	145,405,732.69

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,655,608.50	378,645,323.04	711,362,347.90	1,421,663,279.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	331,655,608.50	378,645,323.04	712,023,224.18	1,422,324,155.72
Дахин үнэлгээний нэмэгдэл хэрэгжсэн дүн				
Тайлант үеийн үр дүн			1,807,299,457.89	1,807,299,457.89
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,655,608.50	377,984,446.76	1,097,744,902.63	1,807,384,957.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			12,328.00	12,328.00
Дахин илэрхийлсэн	331,655,608.5	377,984,446.76	1,097,757,230.63	1,807,397,285.89
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(12,328.00)		(12,328.00)
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг алдагдал/			(118,844,231.56)	(118,844,231.56)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	331,655,608.50	377,972,118.76	978,912,999.07	1,688,540,726.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		202,313,158.13	(202,313,158.13)	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,467,377,100.00	1,321,973,773.44	145,403,326.56	90.1%
УРСГАЛ ЗАРДАЛ	1,467,377,100.00	1,321,973,773.44	145,403,326.56	90.1%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,391,438,900.00	1,259,791,423.44	131,647,476.56	90.5%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	931,023,800.00	817,765,541.36	113,258,258.64	87.8%
Үндсэн цалин	640,296,200.00	588,367,698.90	51,928,501.10	91.9%
Нэмэгдэл	259,339,600.00	204,696,474.53	54,643,125.47	78.9%
Унаа хоолны хөнгөлөлт				
Урамшуулал	31,388,000.00	24,701,367.93	6,686,632.07	78.7%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	116,378,200.00	102,173,909.08	14,204,290.92	87.8%
Тэтгэврийн даатгал	79,137,100.00	70,159,554.17	8,977,545.83	88.7%
Тэтгэмжийн даатгал	9,310,300.00	8,411,225.43	899,074.57	90.3%
ҮОМШӨ-ний даатгал	7,448,200.00	6,564,051.67	884,148.33	88.1%
Ажилгүйдлийн даатгал	1,862,100.00	1,548,252.00	313,848.00	83.1%
Эрүүл мэндийн даатгал	18,620,500.00	15,490,825.81	3,129,674.19	83.2%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	231,062,400.00	231,062,400.00		100.0%
Гэрэл, цахилгаан	44,766,000.00	47,258,041.89	(2,492,041.89)	105.6%
Түлш, халаалт	171,743,400.00	168,835,971.04	2,907,428.96	98.3%
Цэвэр, бохир ус	14,553,000.00	14,968,387.07	(415,387.07)	102.9%
Норматив зардал	31,994,300.00	31,870,873.00	123,427.00	99.6%
Хоол, хүнс	31,994,300.00	31,870,873.00	123,427.00	99.6%
Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.0	2,000,000.0		100.0%
Урсгал засвар	2,000,000.0	2,000,000.0		100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	9,157,200.00	9,157,200.00		100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,317,600.00	1,317,600.00		100.0%
Мэдээллийн технологийн зардал	7,839,600.00	7,839,600.00		100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	69,823,000.00	65,761,500.00	4,061,500.00	94.2%

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	58,063,500.00	54,002,000.00	4,061,500.00	93.0%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,759,500.00	11,759,500.00		100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,938,200.00	62,182,350.00	13,755,850.00	81.9%
Бусад урсгал шилжүүлэг	75,938,200.00	62,182,350.00	13,755,850.00	81.9%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	75,938,200.00	62,182,350.00	13,755,850.00	81.9%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,467,377,100.00	1,265,066,348.00	202,310,752.00	86.2%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,264,915,700.00	1,265,066,348.00	(150,648.00)	100.0%
Орон нутгийн төсвөөс	233,062,400.00	233,062,400.00		100.0%
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,031,853,300.00	1,032,003,948.00	(150,648.00)	100.0%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	202,461,400.00		202,461,400.00	0.1%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,700.00		150,700.00	100.0%
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	202,310,700.00		202,310,700.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		202,313,158.13	(202,313,158.13)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		145,405,732.69	(145,405,732.69)	
АЖИЛЛАГСДЫН ТОО	44.00	46.00	(2.00)	104.5%
Удирдах ажилтан		1.00	(1.00)	
Гүйцэтгэх ажилтан	27.00	28.00	(1.00)	103.7%
Үйлчлэх ажилтан	17.00	17.00		100.0%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй ёс зүйтэй зохион байгуулах, хамтран сурах арга барилыг сургалтад нэвтрүүлэх зорилго дэвшүүлж байна.

Гүйцэтгэлийн үр дүнгийн төлөвлөгөө гарган батлуулж, үүнийхээ дагуу ажлаа төлөвлөж жилд 2 удаа тайлан бэлтгэж гаргадаг байна.

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 36 арга хэмжээний хүрээнд баталснаас нийт 81.4 %-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 98,348.4 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	202,313.2	145,405.7	(56,907.5)
Авлага	26.6	0	(26.6)
Бараа материал	58,917.7	60,649.2	1,731.5
Үндсэн хөрөнгө	1,546,127.5	1,502,981.7	(43,145.8)
Нийт хөрөнгө	1,807,384.9	1,709,036.5	(98,348.4)
Өр төлбөр	0	20,495.8	(20,495.8)
Засгийн газрын хувь оролцоо	1,097,744.9	978,912.9	(118,844.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,807,384.9	1,709,036.5	(98,348.4)

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 56,907.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийг бүрэн зарцуулсантай холбоотой.

Бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 6,427.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгаснаас буурч, мөн 6,838.9 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаар нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд тоног төхөөрөмж 60,448.6 мянган төгрөг, тавилга эд хогшил 1,826.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 21,729.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 34,928.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,826.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 25,519.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 20,495.8 мянган төгрөгөөр өссөн нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг төлж барагдуулаагүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 978,912.9 мянган төгрөг болж 98,348.4 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,202,531.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 264,845.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 1,467,377.4 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 1,467,377.4 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 1,321,973.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,264,915.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, зарцуулсан байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,321,973.8 мянган төгрөг буюу 90.1 хувьтай байна.

Хүснэгт 2.

<i>/мянган төгрөг/</i>					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1,467,377.1	1,321,973.8	145,403.4	90.1%
1.1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	3,135.9	3,135.9	0	100%
1.2	80312 Сургалт семинар	1,567.9	1,567.9	0	100%
1.3	81605 Эрүүл мэндийг дэмжих	4,486.9	2,563.4	1,923.5	57.1%
1.4	81801 Үдийн цай хөтөлбөр	75,938.2	62,182.4	13,755.9	81.9%
1.5	81806 байрны үйлчилгээ	54,888.4	50,711.8	4,176.6	92.4%
1.6	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	36,362.1	35,233.5	1,128.6	96.8%
1.7	81823 Багшийн ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	7,055.7	6,197.0	858.7	87.8%
1.8	81834 стандарт сургалтын төлөвлөгөө-цалин	864,878.4	770,025.1	94,853.3	89.0%
1.9	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	184,532.9	155,976.8	28,556.1	84.5%
1.10	80111 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	233,062.4	233,062.4	0	100%
1.11	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	150.7	0	150.7	0%
1.12	81848 Түрээсийн сурах бичиг	1,317.6	1,317.6	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 334,649.5 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоол хүнс 90,929.9 мянган төгрөгөөр нээлттэй тендер шалгаруулахаар, 49,798.6 төгрөгийн бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, бараа үйлчилгээний бусад зардал, мэдээлэл технологийн зардлуудыг шууд худалдан авалтаар, 203,998.6 төгрөгийн тогтмол зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 372,163.45 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу хийсэн байна. Худалдан авалтын дүн өссөн нь түлш халаалтын төлбөр нэмэгдсэнтэй холбоотой.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар анхан шатны баримтын бүрдэл хангаж гүйлгээ хийх, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, ХХОАТ-ын тайланг үнэн зөв тайлагнаж хэвших зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав нар хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээ Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,185,772.3 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 17,786.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,339.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гаргаагүй, хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Ерөнхий боловсролын 4-р сургуулийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, 158 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Үүнд: цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 20 орлогын, 17 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 9 шийдвэрийг хуулийн хугацаанд байршуулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	74,214.4	1	74,214.4	100%
Зөвлөмж	1	1,873.0	1	1,873.0	100%
Нийт дүн	2	76,087.4	2	76,087.4	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 2,595,011.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2,595,011.9 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдлийг 385,721.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнгээс 646,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Тайлант жилийн эд хөрөнгийн тооллогын үр дүнг хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгаж нэгтгээгүй, илтгэх хуудсыг хянаж хүлээн аваагүй 1,563,290.2 мянган төгрөг байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-д "Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно" гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 24,451.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, аудитын явцад 24,451.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.1 Зөвлөмж

1. Анхан шатны баримтын бүрдэл хангахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 1,317.6 мянган төгрөгийн зардлын гүйлгээ хийсэн байна. Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Өгсөн зөвлөмж: Зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн и баримтын бүрдэл хангаж гүйлгээ гаргаж хэвших

2. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд урсгал зардалд 20,495.9 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж өр авлага үүсгэхгүй ажиллах.

3. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хувь хүний орлогын албан татварын тайлангийн дүн тооцоологдсон цалингаас 2,637.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах" гэж заасантай, санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тооцоологдсон цалингийн зардлыг Хувь хүний орлогын албан татварын тайланд зөв дүнгээр тусгагдсан эсэхийг хянаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлагналтай холбоотой алдаа	1	385,721.7			1	385,721.7	1	385,721.7				
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнгээс зөрүүтэй	1	646,000.0			1	646,000.0	1	646,000.0				
Хөрөнгийн тооллогын дүн нэгтгээгүй	1	1,563,290.2			1	1,563,290.2	1	1,563,290.2				
Дүн	3	2,595,011.9			3	2,595,011.9	3	2,595,011.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэж ажилласан	1	20,495.9					1	20,495.9				
ХХОАТ-ын тайлан зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	2,637.6					1	2,637.6				
Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй гүйлгээ хийгдсэн	1	1,317.6					1	1,317.6				
Дүн	3	24,451.1					3	24,451.1				